


Бэлтгэсэн: ШУА-ийн Газарзүй-Геокологийн Хүрээлэнгийн Цөлжилтийн судалгааны салбарын ЭШДаА О. Ишцог

“NDSI индекс ашиглан Сэлэнгэ аймгийн Алтанбулаг сумын элс бүхий талбайн хэв шинж болон түүний өөрчлөлтийг тооцох нь”


Сэлэнгэ аймгийн Алтанбулаг сум нь Элсний мужлалын ангиллаар Сэлэнгэ-Туул голын мужийн Шаамарын дэд мужид хамаарагдах ба салхи-голын гарал үүслийн хэв шинжид багтана [1].

3. Мөнхөө (1972) Сэлэнгэ мөрөн урсан өнгөрч буй түүний өргөн хэсгүүд болох Цагаан тал, Мөрөн татуурга, Тэрэгт, Сэлэнгэ Бүрэнгийн хотгоруудад давхраат элс тархсаныг тэмдэглэж, Сэлэнгийн ай савын дээд хэсэг дэх уул хоорондох хотгорын хажуу болон голын хөндийн өндөр дэнжүүдийг бүрэлдүүлэгч тэдгээр элсний насыг плиоцены сүүл, Q-ийн дунд үе хоёрын хооронд (Q₁) өөрөөр хэлбэл дөрөвдөгч галавын эхэн үед хуримтлагдсан байж болох юм гэж үзжээ. Сүхбаатар хотоос баруун урагш, Царам (894.0) уулын хойгуур Орхон Сэлэнгийн бэлчрийн тэгш тал болон, Алтанбулаг хотоос баруун урагш голын хөндийн хоёр талаар нэлэнхий дарагдмал элстэй, тэдгээрийн зарим нь элэгдэл эвдрэлд орж довцог, молцог, ганц нэг манхан үүсгэсэн байх ба эдгээр элсний гарал, насны талаар Е.И. Селиванов (1967) өөрийн санаа бодлоо илэрхийлжээ. Тэрээр, дээрх хэсгийн элс газрын гүнээс бялхаж гарсан хүрмэн лав эртний голын усыг хааснаас тогтсон неоген-дөрөвдөгч галавын асар том нуурын хурдас юм гэж тэмдэглэн үлдээсэн байдаг [2].

Бид элсний ялгаврын нормчилсон индексийг Ландсат 7 болон 8 дугаар хиймэл дагуулын мэдээг ашиглан бодуулахад дараах үр дүн гарч байна (зураг 1;2).




Зураг 1. Алтанбулаг сумын 2003 болон 2018 оны элс бүхий талбай



Зураг 2. Алтанбулаг сумын 2003 болон 2018 оны элс бүхий талбай

Дээрх зураглалаас харахад элс бүхий талбай Хяраан гол болон Давст нуурын хөндий орчмоор бага зэрэг нэмэгдсэн харин элсэрхэг газар тариалангийн талбай болон Бага тал мөн Цайлангийн хонхор, Хутаг-Өндөр уулын орчмоор шинээр элсжиж буй нь харагдаж байна (хүснэгт 1).



Хүснэгт 1. Алтанбулаг сумын элс болон элсэрхэг газрын талбайн өөрчлөлт

Он	2003	2018	Өөрчлөлт
	Талбайн хэмжээ (км ²)		
Элс	14.4	18.9	+ 4.5
Элсэрхэг газар	25.4	68.8	+ 43.4

2003 болон 2018 оны хооронд нийт 15 жилийн хугацаанд элсний талбай 4.5 км² нэмэгдсэн нь үндсэн хэлбэрүүд өөрчлөгдөөгүй Хутаг-Өндөр уулын бэл орчимд багахан талбай шинээр нэмэгдсэн нь харагдаж байна. Харин элсэрхэг газрын талбай маш их хэмжээгээр буюу 43.4 км² –аар нэмэгдсэн байна (1 дүгээр тахирмаг). Энэ нь байгаль цаг уурын болон нийгмийн хүчин зүйлийн нөлөөн

дор үйлчлэл явагдсантай холбоотой хэмээн таамаглаж байна. Тухайлбал, малын тоо толгой болон газар тариалангийн талбай хэт өссөн, агаарын температур олон жилийн дунджаас нэмэгдэн хур тунадас багассан зэрэг болно.

Сумын нутаг дэвсгэрийн хойд хэсэг ерөнхийдөө уулс хоорондын хөндий хотос хэлбэр зонхилох ба хөрсний хувьд элс бүхий талбайтай хэсгээр хуурай хээрийн ба цөлжүү хээрийн хэв шинжийн ширэгт сул чандруулаг, мараалаг нугат хүрэн, нунтаг карбонатлаг хөрс тархсан байна.


Бид дараах зураглалд илэрсэн элс бүхий талбайг шалгах зорилгоор хээрийн судалгаагаар координат авч хилийн тодролыг давхцуулсан (2,3 дугаар зураг).

1. Гялаан нуурын зүүн талын довцог элс



Зураг 2. Гялаан нуурын зүүн талын элс

Гялаан нуурын баруун талын энэхүү элс нь 1984 оны 1:100.000 масштаб бүхий зурагт мөн дүрслэгдсэн байна (зураг 2).




Зураг 2. 1984 оны Байрзүйн зурагт Гялаан нуурын зүүн талын элс дүрслэгдсэн байдал

2. Сумын төвийн баруун урд хэсэгт байрлах Хиагтын хоолой дахь элс



Зураг 3. Хиагтын хоолой дахь элс



Зураг 3. 1984 оны Байрзүйн зурагт Хиагтын хоолой дахь элс дүрслэгдсэн байдал

Тус сумын элс нь ерөнхий хуримтлалын хэлбэрийн хувьд Бүрхэвч болон Довцог багахан талбайд Молцог элс тархсан байна. Дээрх хэлбэрийн элсийг дэлгэрүүлбэл: Бүрхэвч элс их төлөв талархаг газар, долгиот тал, ухаа гүвээрхэг гадарга ба бэлийн хэвгий талыг харьцангуй тэгш үеэр хучиж тогтсон байдаг. Бүрхэвч элсний зузаан төдийлөн их биш, дунджаар 10-60см, хааяа 1м хүрэх ба ихэнхдээ өвслөг, сөөгөнцөр ургамлаар, зарим тохиолдолд харгана, буйлс, заг зэрэг сөөглөг ургамлаар бэхлэгдсэн буюу тэдгээрт бэхэжсэн байдаг. Тус элсний өөр нэг хэлбэр бол төгс ургамалжсан дарагдмал байдалтай бүрхэвч элс юм. Ийм төрлийн элстэй газрын ургамал бүрхэвчийг зүй бус хөндөх, бэлчээрт сэлгээгүй давтан давтан ажиглах, нүх шуудуу ухаж сэндийчих зэргээр өнгөн хөрсийг гэмтээхээс байнга сэргийлж аж ахуй, зам

тээвэрт ашиглахдаа онцгой болгоомжтой, зөв харьцах, өөрөөр хэлбэл ашиглалт хамгаалалтыг зохистой хослох шаардлагатай. Эс тэгвэл элс нь сулран хийсэж өргөн уудам нутаг бэлчээр элсжих цөлжих аюултай болно.

Дов, овоо хэлбэртэй, төдийлөн өндөр биш (1-4м), салхин талын болон салхины доод талын хажуу нь морфологийн ялгаваргүй, дугуй буюу бага зэрэг сунасан плантай элсэн хуримтлалын эерэг хэлбэрийг довцог элс гэнэ [2].

АШИГЛАСАН МАТЕРИАЛ

1. [1] – Монгол Улсын Үндэсний Атлас, 2006
2. [2] - Баасан , Т. (2003). Монгол орны элс. Улаанбаатар: Улсын Их Хурлын Тамгын газрын хэвлэх үйлдвэр.
3. Loadmap.net
4. Glovis.usgs.gov